БАТЛАВ

БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Т.НЯМ-ОЧИР

“ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДУНД, АХЛАХ АНГИЙН СУРАЛЦАГЧДАД АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ, ХИЧЭЭЛ СОНГОЛТОД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ” ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 11 дугаар сарын 17-ны өдөр Улаанбаатар хот

№	Мэдээлэл	Үзүүлэлт
1	Зорилго:	Ерөнхий боловсролын сургуулийн Ахлах ангийн суралцагчдын мэргэжил сонголтыг хувь хүний сэтгэл зүй, сонирхол, авьяас, зан төлөвт тулгуурлан оновчтой тодорхойлох, тэдэнд мэргэжлийн чиг баримжаа олгох, бүлгийн зөвлөгөө өгөх, мэдлэг, арга зүйгээр хангах замаар хүүхдийн боловсрол, ирээдүйн ажил, хөдөлмөр эрхлэлтийн чиг хандлагыг тодорхойлж, урт хугацааны карьер төлөвлөлт хийхэд дэмжлэг үзүүлэх.
2	Хугацаа:	**Үе шат 1 (2025 оны IV улирал):** Зургаан аймгийн /Сэлэнгэ, Булган, Өмнөговь, Увс, Дархан-Уул, Дорнод/ 12 сургуулийн 2461 сурагч, нийслэлийн 9 дүүргийн 9 сургуулийн 2608 суралцагчийг “АЖИЛ МЭРГЭЖЛИЙН СОНИРХОЛ ТОДОРХОЙЛОХ” тестэд хамруулах. **Үе шат 2 (2026 оны I улирал):** “Ажил мэргэжлийн сонирхол тодорхойлох” тестийн үр дүнг тайлбарлах, уялдаа холбоог ойлгох, мэргэжлээ зөв сонгоход хэрхэн ашиглах талаар бүлгийн зөвлөгөө, сургалтыг үе шаттай зохион байгуулах.
4	Санхүүжилтийн эх үүсвэр, мөнгөн дүн:	• Улсын төсөв - **222,241,000** төгрөг • Төсөвт ажлын даалгавар, бүтээгдэхүүн, үйлчилгээ, сургагч багш нарын ажлын хөлс болон замын зардал, томилолтын зардал багтана.
5	Захиалагч байгууллага	• Боловсролын ерөнхий газар
6	Хамрах хүрээ:	• Сэлэнгэ, Булган, Өмнөговь, Увс, Дархан-Уул, Дорнод аймгийн ерөнхий боловсролын 12 сургуулийн 2461 суралцагч, • Нийслэлийн ерөнхий боловсролын 9 сургуулийн 2608 суралцагч, • 21 сургуулийн 420 багш, төсөлд хамрагдсан суралцагчдын эцэг эх, харгалзан дэмжигч нар.
7	Үндэслэл	1. Монгол улсын хэмжээнд 2024 оны байдлаар ажилгүйдлийн түвшин 5.3 хувь байгаа боловч 15-24 насны залуучуудын хувьд 13.8 хувь буюу залуучуудын ажилгүйдлийн түвшин харьцангуй өндөр үзүүлэлттэй байна. 2. ГБХНХЯ, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, судалгаа, үнэлгээний институтээс хийсэн “Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал-2024” судалгааны тайланд залуу ажилтнууд, сургууль төгсөгчид хөдөлмөрийн зах зээл дээр гарахад тулгардаг гол асуудал нь ур чадварын дутагдал байдаг талаар онцолсон байна.

		3. “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай“ хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т “Ерөнхий боловсролын зорилго нь суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино“, 20 дугаар зүйлийн 20.10-т “Суралцагчийн суралцах үйл ажиллагаа, хөгжил төлөвшлийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэсэн хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа нь ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны салшгүй хэсэг байна“ гэж заасан. 4. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2.3-т “Суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжааг олгож, мэргэжлийн эрх олгох, сонгох боломжтой төрөлжсөн ахлах сургуулийг аймаг, дүүрэг бүрд байгуулна”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/96 дугаар тушаалаар баталсан “Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө”-ний 3.1.1.6-д “Ерөнхий боловсролын сургуульд мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг өргөжүүлэх, жендерийн мэдрэмжтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж тус тус заасан. 5. Олон улсын туршлагаас үзэхэд мэргэжил сонголтын чиг баримжааг 8-р ангиас нь зан чанар, сонирхол, оюуны чадамж, тухайн сурагчдын онцлог зэргийг оношилгоо тест хийж, мэргэжлийн хүний зөвлөгөө чиглүүлэг дээр үндэслэн хийж байна.
8	Хүрэх үр дүн	1. Төсөлд хамрагдсан сургуулийн ахлах ангийн сурагчдад өөрийн зан чанарын онцлог, давуу сул тал, ажил мэргэжлийн сонирхолоо тодорхойлсон “АЖИЛ МЭРГЭЖЛИЙН СОНИРХОЛ ТОДОРХОЙЛОХ” тестийн тайлан, зөвлөгөө авсан байна. 2. Багш, эцэг эхчүүдийн мэргэжил сонголтын талаар мэдлэг, ойлголт сайжирч суралцагчийн зан чанарын онцлог, давуу болон сул тал, ажил мэргэжлийн сонирхлыг тодорхойлсон тестийн тайлан дээр тулгуурлан мэргэжил сонголтыг дэмжин чиглүүлэх чадвар дээшилсэн байна.
9	Гүйцэтгэх ажил:	<u>НЭГ. “АЖИЛ МЭРГЭЖЛИЙН СОНИРХОЛ ТОДОРХОЙЛОХ”ОЛОН УЛСАД БАТАЛГААЖСАН СЭТГЭЛ ЗҮЙН ТЕСТ ОНОШИЛГОО ХИЙХ:</u> 1.1 Суралцагч тус бүрийн хувь хүний онцлог зан чанар, мэргэжлийн сонирхлыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлж, ирээдүйн мэргэжил сонголтын зөв шийдвэрт дэмжин чиглүүлэх зорилгоор олон улсад хэрэгжиж баталгаажсан “АЖИЛ МЭРГЭЖЛИЙН СОНИРХОЛ ТОДОРХОЙЛОХ” тест оношилгоо хийх. - “АЖИЛ МЭРГЭЖЛИЙН СОНИРХОЛ ТОДОРХОЙЛОХ” тест нь RIASEC загварт суурилсан, технологийн дэвшлийг ашиглаж зохион байгуулах боломжоор хангагдсан байх. - Тест оношилгоо зохион байгуулах үйл ажиллагааг холбогдох сургуультай хамтран сургууль, анги тус бүрээр бүлэг үүсгэн тест бөглөх заавар, зөвлөмжийг урьдчилан танилцуулж, сонгогдсон суралцагчдыг бүрэн хамруулах.

		1.2 Суралцагч тус бүрийн "АЖИЛ МЭРГЭЖЛИЙН СОНИРХОЛ ТОДОРХОЙЛОХ ТЕСТ" оношилгооны тайланг боловсруулж, гар утас, электрон тоног төхөөрөмжөөсөө татаж аван ашиглах боломжтой байдлаар илгээдэг байх. <u>ХОЁР. "АЖИЛ МЭРГЭЖЛИЙН СОНИРХОЛ ТОДОРХОЙЛОХ" ТЕСТИЙН ҮР ДҮНГ ТАЙЛБАРЛАХ, УЯЛДАА ХОЛБООГ ОЙЛГОХ, МЭРГЭЖЛЭЭ ЗӨВ СОНГОХОД ХЭРХЭН АШИГЛАХ ТАЛААР БҮЛГИЙН ЗӨВЛӨГӨӨ, СУРГАЛТЫГ ҮЕ ШАТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ</u> - "АЖИЛ МЭРГЭЖЛИЙН СОНИРХОЛ ТОДОРХОЙЛОХ" тестийн үр дүнг тайлбарлах, бүлгийн зөвлөгөөг төслийн хамрах хүрээний сургууль тус бүрд танхимаар зохион байгуулах. - Суралцагчдад хувь хүний сэтгэл зүй, сонирхол, авьяас, зан төлөвт тулгуурлан ажил мэргэжлээ хэрхэн, зөв сонгох олон улсын сайн туршлага, боломж, карьер төлөвлөлтийн анхан шатны мэдлэг олгох сургалт зохион байгуулах. - Үнэлгээ, сургалт, зөвлөгөөний явцад хяналт тавьж чиглүүлэг өгөх бөгөөд сургалт, зөвлөгөөний дараа сэтгэл ханамжийн судалгааг түүвэр байдлаар авч үр дүнг танилцуулах. - Үр дүнд тулгуурлан цаашид боловсролын салбарын бодлого, дүрэм журамд энэ асуудлаар сайжруулах санал зөвлөмж өгөх. - Ахлах ангийн суралцагчдын мэргэжил сонголтыг зөв чиглүүлэх, урт хугацааны карьер төлөвлөлт хийхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор эцэг эх, багш нарт зориулсан онлайн сургалтын хөтөлбөр боловсруулж сургуулиудын цахим хуудсанд байршуулах.
10	Тавигдах шаардлага:	1. Албан ёсны эрхтэйгээр ашиглах "АЖИЛ МЭРГЭЖЛИЙН СОНИРХОЛ ТОДОРХОЙЛОХ" тест нь олон улсын түвшинд болон Монгол улсад ашиглагдаж баталгаажсан тест байна. Америкийн сэтгэл судлалын холбоо (APA) болон Олон улсын тестийн комисс (ITC)-с гэх мэт мэргэжлийн байгууллагуудаас тогтоосон сэтгэл зүйн үнэлгээний баталгаажуулалтын стандартуудыг хангасан байх. 2. "АЖИЛ МЭРГЭЖЛИЙН СОНИРХОЛ ТОДОРХОЙЛОХ ТЕСТ"-ийн шийдэл нь шинэлэг, орчин үеийн дэвшилтэт технологийг шинжлэх ухааны баталгаажуулалттай хослуулан хувь хүний авьяас, чадамжуудыг бүрэн тодорхойлох чадвартай, сэтгэл зүйн үнэлгээний стандарт болон аюулгүй байдлыг хангасан арга зүйд суурилсан байх. 3. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр үнэлгээ хийх, сургалт, зөвлөгөө өгөх зөвшөөрөл бүхий албан ёсны эрх бүхий мэргэшсэн байгууллага байх. 4. Мэргэжлийн чиг баримжаа олгох, карьер зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн үнэлгээг олон улсын арга аргачлалыг ашиглан зохион байгуулах чиглэлээр 5-аас дээш жил тасралтгүй үйл ажиллагаа эрхэлсэн туршлагатай байх. 5. Сүүлийн 2 жилийн хугацаанд ижил төстэй ажил үйлчилгээг амжилттай гүйцэтгэсэн туршлагаа нотлох баримт бичгийг (гэрээ, тайлан, санал сэтгэгдэл) хавсаргасан байх.

		6. Мэргэжлийн зөвлөх, сургагч багш, сэтгэл зүйчийн бүрэлдэхүүнтэй багтай байх. 7. Танхим ба онлайн хосолсон сургалт, зөвлөгөө зохион байгуулдаг багадаа 5 жилийн туршлагатай байх. 8. Санхүүгийн тайлан, балансыг жил бүр тайлагнадаг байх.
11	Явцын хяналт	• Захиалагчийн зүгээс зөвлөх үйлчилгээний явцын хяналт хийж, төсөл хэрэгжүүлэгч талуудын уулзалтыг шаардлагатай үед зохион байгуулж, гарсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
12	Хүлээлгэн өгөх тайлан:	1. Төсөлд хамрагдсан сургуулиудад, сургууль тус бүрээр нийт сурагчдын тестийн үр дүн, “Сурагчдын зан төлөвийн онцлог, ажил мэргэжлийн сонирхлын нийтлэг дүр төрх “ судалгааны тайлан. 2. Аймаг, дүүрэг бүсийн хэмжээнд хамрагдсан сургуулийн судалгааны үр дүн дата-д үндэслэн боловсруулсан бодлогын зөвлөмж.

--o0o--